

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10	Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	13
4.2	Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	15
4.3	Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	17
4.4	Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	20
4.5	Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.....	21
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
Ц.ТӨМӨР-ОЧИР ТАНАА

2019.03.01 № 06/372
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус эмнэлгийн дарга Ц.Төмөр-Очир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дугаар сарын 12-наас 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ийн аудитын менежер Ж.Батнасан хариуцаж хэрэгжүүлэв.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна. П.Н.Шастины

нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны залруулсан Санхүүгийн тайланг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 129 тоот албан бичгээр ирүүлсэн.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг нь Үйлчлүүлэгч төвтэй, дээд зэргийн чанартай тусламжийг үзүүлэгч “Үндэсний тэргүүлэгч эмнэлэг” гэсэн алсын хараатай, “Бид өдөр тутмын эмнэлзүй сургалт, судалгааны нэгдмэл үйл ажиллагааны тусламжтайгаар эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндэд үнэ цэнэтэй өөрчлөлтийг бий болгохыг зорино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- улсын хэмжээнд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх,
- анагаах ухааны сургалт, судалгаа явуулах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх,
- эмнэлгийн болон, бусад байгууллага, иргэдэд мэргэжил арга зүйн гурав дахь шатны лавлагаа тусламжаар хангах

Люксембургийн Их Вант Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын хооронд “Зүрх судасны эмчилгээ үйлчилгээг сайжруулах, Зүрх судасны төвийг бэхжүүлэх” МОН/006 төслийн тухай протоколд оруулсан Өөрчлөлт № 1 –ээр буцалтгүй тусламжийн

хэмжээг 4,500.0 мянган евро хүртэл нэмэгдүүлсэн байна. МОН/006 төслийн харилцах дансны гүйлгээ 2017 оноос эхлэн П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн санхүүгийн тайланд тусгагдаж байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг Азийн Хөгжлийн Банкны “Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх” техник туслалцааны ТА-9037 МОН төслөөс зарласан сонгон шалгаруулалтанд шалгарч 2019 онд бие даасан байдалд шилжихээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 07 тоот тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим тусламж үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн жагсаалт, түүний жишиг үнэ, даатгалын сангаас олгох төлбөрийн хэмжээ”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх, протез, ортопедийн зардлыг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-уудыг хүчингүй болгож, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 6 сарын 25-ны өдрийн 11 тоот тогтоолоор шинэчлэн баталж 2018 оны 7 сарын 16-наас эхлэн мөрдсөн.

Өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн даатгалын сангаас олгох төлбөрийн хэмжээг 2018 оны 7 сарын 16 хүртэл тодорхой мөнгөн дүнгээр тогтоосон, зөрүүг даатгуулагч төлдөг байсан бол шинэ журмаар гэрээний үнийн 75 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр өөрчлөн тогтоосон тул даатгуулагч өндөр өртөгтэй хэрэгслийн үнийн 25 хувийг төлөх болсон.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн даргын 2018 оны Б/434 тоот тушаалаар Монгол улсын засгийн газрын “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2018 оны 264, “Тогтоолын хавсралтад

нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2018 оны 263 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж, сувилагч, үйлчилгээний ажилчдын цалинг 2018 оны 9 сараас 1 нээс эхлэн 1-2 шатлалаар ахиулан баталснаар шатлал ахисан ажилчдын сарын цалин дунджаар 13-20 хувиар нэмэгджээ.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлж үнэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн онлайн смарт "Unicus" програм хангамжийг ашиглаж байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “дунд” байна. Тус эмнэлгийн бүтцэд чанар, дотоод аудитын алба нь албаны дарга, чанарын менежер 2, гэрээт дотоод аудитор 1 нийт 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эмчилгээ үйлчилгээний чанарын хяналт, дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонголоо.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны нийт зардал 37,133,801.7 мянган төгрөгийн 1 хувь болох 371,338.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,108.3	
2	Албан шаардлага өгсөн	2	906,682.2	
	Дүн	3	907,790.5	

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 33,983,957.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 33,339,850.0 мянган төгрөг буюу 98.1 хувьтай буюу 644,107.4 мянган төгрөгөөр хэмнэгджээ. Эмнэлгийн өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 834,087.1 мянган төгрөгөөр тасарсан, бараа ажил үйлчилгээний бусад зардал 896,368.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.10 Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх, бүртгэлд тусгахтай холбоотой аргачлал, зааврын дагуу “Файн эстимэйт” ХХК-аар хийлгэж үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний материалыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар хянуулжээ.

“Файн эстимэйт” ХХК тус эмнэлгийн 1 газрын эзэмших эрхийг 6,185,190.0 мянган төгрөгөөр, 42 ширхэг барилгыг 25,242,650.0 мянган төгрөгөөр тус тус үнэлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар газрын эзэмших эрхийг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтанд заасан 1м.кв газрын бүсийн үнэлгээгээр тооцож 1,820,695.0 мянган төгрөг болгон бууруулж, эмчилгээний хоолны блок, бассейн гэх 2 барилгын итгэлцүүрийг өөрчилсний дүнд барилгын үнэлгээг 25,315,839.3 мянган төгрөг болгон нэмэгдүүлж залруулсан. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хянасан ажилтан, “Файн эстимэйт” ХХК-ийн үнэлгээчнээр тус тус баталгаажуулан гарын үсэг зуруулсан байна.

Дахин үнэлгээний үр дүнг 2018 оны санхүүгийн тайланд дараахь байдлаар тусгажээ:

Баянгол дүүргийн 5 дугаар хороонд байрлах нийт 56229 м.кв газрын эзэмших эрхийг 1,820,695.0 мянган төгрөгөөр үнэлж, бусад биет бус хөрөнгө болон Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлсэн;

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг 15 барилга, нийтийн эзэмшлийн 14, инженерийн 13 байгууламжийг 25,315,839.3 мянган төгрөгөөр үнэлж, барилга байгууламжийн данс болон дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлсэн.

2.11 Шилэн дансны мэдээлэл

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр

ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант онд нийт 1469 мэдээллийг шилэн дансанд оруулсан байна.

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар орлогын төлөвлөгөө биелүүлэх, орлогыг харилцах дансаар хүлээн авах, нэгжүүдийн усны хэрэглээнд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, зардлыг бууруулах 3 зөвлөмж өгсөн. Тус эмнэлгийн орлогын төлөвлөгөө тасарсан, усны зардал төсвөөс хэтэрсэн учир 2 зөвлөмж биелээгүй, орлогыг 2018 оны 5 сарын 1-нээс эхлэн Төрийн банкны харилцах дансаар авсан учир 1 зөвлөмжийг биелүүлсэн гэж үзэж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар

3.1.1. Илрүүлэлт:

Төсвийн байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 834,087.1 мянган төгрөгөөр тасалсан.Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг "...төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2. Эрсдэл:

Тус эмнэлгийн тухайн жилийн батлагдсан төсөвт тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт доголдож, үйл ажиллагаанд хүндрэл учрах эрсдэлтэй.

3.1.3. Шийдвэр:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг мөрдөж орлогын төлөвлөгөө биелүүлэх албан шаардлага хүргүүлэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлж ажиллана.

3.2. Усны зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн талаар

3.2.1. Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 –т “Бүх шатны төсвийн захирагч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчиж усны зардлыг батлагдсан төсвөөс 72,595.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

3.2.2. Эрсдэл:

Уснаас бусад зардлын санхүүжилтэнд хүндрэл учрах эрсдэлтэй.

3.2.3. Шийдвэр:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалтыг мөрдөж нэгжүүдийн усны хэрэглээг хянаж, зардал бууруулах албан шаардлага хүргүүлэх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаас хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлж ажиллана.

3.3. Түрээсийн байгууллагын ашиглалтын зардлын талаар

3.3.1. Илрүүлэлт:

Тус эмнэлгийн 429 м2 талбай бүхий өрөөнүүдэд байрлаж үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Анагаах ухааны хүрээлэнгийн ашиглалтын бодит зардалд гэрээний дагуу хүрээлэнгээс нэхэмжилж хүлээн авсан төлбөрөөс 1,108.3 мянган төгрөгөөр илүү зардал төлж Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Бүх шатны төсвийн захирагч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй.

3.3.3. Өгөх зөвлөмж:

Анагаах ухааны хүрээлэнтэй байгуулсан гэрээг ашиглалтын бодит зардалтай нь уялдуулан шинэчлэх, түрээсийн төлбөрийн асуудлыг дээд байгууллагад тавьж шийдүүлэх зөвлөмж хүргүүлэх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаас хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлж ажиллана.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4 043 912 041,15</u>	<u>3 643 194 144,48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1 084 969 123,44	17 153 897,85
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	16 710,00
31110	Төгрөг	-	16 710,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1 084 969 123,44	17 137 187,85
3121	Төгрөг	476 273 326,62	696 100,75
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	476 273 326,62	696 100,75
3122	Гадаад валют	608 695 796,82	16 441 087,10
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах	608 695 796,82	16 441 087,10
33	АВЛАГА	236 280 000,00	422 909 928,16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	41 211 000,00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	192 900 000,00	226 031 686,00
335	Бусад авлага	2 169 000,00	196 878 242,16
3351	Байгууллагаас авах авлага	2 169 000,00	196 878 242,16
35	БАРАА МАТЕРИАЛ	2 722 662 917,71	3 203 130 318,47
351	Түүхий эд материал	649 929 265,35	1 021 513 290,57
35130	Эм боох материал	649 929 265,35	1 021 513 290,57
354	Хангамжийн материал	2 072 733 652,36	2 181 617 027,90
35410	Бичиг хэргийн материал	521 653,00	708 100,00
35420	Аж ахуйн материал	227 000,00	8 628 145,00
35430	Сэлбэг хэрэгсэл	1 360 000,00	-
35440	Түлш, шатах тослох материал	2 673 611,70	4 343 908,65
35460	Хүнсний материал	2 623 591,80	3 271 600,40
35470	Бусад хангамжийн материал	2 065 327 795,86	2 164 665 273,85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29 194 011 258,39</u>	<u>39 255 419 227,58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29 194 011 258,39	39 255 419 227,58
392	Биет хөрөнгө	29 168 597 925,02	37 424 161 707,37
39201	Барилга, байгууламж, орон сууц	31 405 263 851,55	25 346 869 313,76
39202	Хуримтлагдсан элэгдэл	15 335 790 905,32	23 575 833,07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	239 295 750,00	239 295 750,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	193 716 492,77	208 849 977,72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26 340 082 124,11	29 670 231 834,66
39206	Хуримтлагдсан элэгдэл	14 004 212 089,58	18 083 837 833,39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1 827 202 145,36	1 896 968 233,36
39208	Хуримтлагдсан элэгдэл	1 109 526 458,33	1 412 939 780,23
393	Биет бус хөрөнгө	25 413 333,37	1 831 257 520,21
39301	Програм хангамж	353 093 470,00	353 093 470,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	327 680 136,63	342 530 969,79
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1 820 695 020,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>33 237 923 299,54</u>	<u>42 898 613 372,06</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>33 237 923 299,54</u>	<u>42 898 613 372,06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	33 237 923 299,54	42 898 613 372,06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15 283 949 417,50	17 104 644 437,50
51101	Өмч: - төрийн	15 283 949 417,50	15 283 949 417,50
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	1 820 695 020,00

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	7 310 673 183,88	4 776 452 297,53
51210	Өмнөх үеийн үр дүн	9 624 075 001,39	7 310 673 183,88
51220	Тайлант үеийн үр дүн	-2 313 401 817,51	-2 534 220 886,35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10 643 300 698,16	21 017 516 637,03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>33 237 923 299,54</u>	<u>42 898 613 372,06</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32 518 690 187,90	34 586 364 843,63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4 853 451 733,70	4 620 724 343,63
120	Нийтлэг татварын бус орлого	4 280 673 822,70	4 618 139 343,63
120002	Хүүгийн орлого	5 707 490,15	12 300 151,23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4 181 730 432,55	4 517 165 892,40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4 115 135 432,55	4 341 233 852,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66 595 000,00	158 071 040,40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	17 861 000,00
120005	Түрээсийн орлого	66 969 000,00	88 673 300,00
120009	Бусад орлого	26 266 900,00	-
122	Тусламжийн орлого	572 777 911,00	2 585 000,00
122001	Хандив тусламж /дотоод/	117 098 520,00	2 585 000,00
122002	Хандив тусламж /гадаад/	455 679 391,00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27 665 238 454,20	29 965 640 500,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5 328 813 400,00	7 722 196 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5 145 554 600,00	5 222 196 000,00
131005	Хөрөнгийн санхүүжилт	183 258 800,00	2 500 000 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 615 558 894,20	425 676 100,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1 228 693 085,00	8 016 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	377 652 200,00	239 272 100,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9 213 609,20	178 388 000,00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20 720 866 160,00	21 817 768 400,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20 720 866 160,00	21 817 768 400,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	34 841 874 958,70	37 124 853 643,16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34 841 874 958,70	37 124 853 643,16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34 329 375 750,69	36 815 085 584,37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8 266 468 930,93	8 535 586 731,98
210101	Үндсэн цалин	4 529 981 345,16	4 670 071 601,36
210102	Нэмэгдэл	3 086 863 097,74	3 218 423 344,90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	649 624 488,03	647 091 785,72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	919 868 267,80	1 034 051 943,57
210201	Тэтгэврийн даатгал	593 252 754,81	707 015 234,98
210202	Тэтгэмжийн даатгал	68 422 508,66	69 660 038,23
210203	ҮОМШӨ-ний даатгал	81 995 935,03	77 620 400,01
210204	Ажилгүйдлийн даатгал	15 963 790,08	16 283 307,17
210205	Эрүүл мэндийн даатгал	160 233 279,22	163 472 963,18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	737 850 400,00	731 713 820,84
210301	Гэрэл, цахилгаан	328 965 933,00	327 156 004,00
210302	Түлш, халаалт	219 452 680,39	195 239 735,00
210303	Цэвэр, бохир ус	189 431 786,61	209 318 081,84
2104	Хангамж, бараа материалын зардал	145 322 324,97	298 283 360,36
210401	Бичиг хэрэг	24 299 981,85	25 739 700,00

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	32 150 313,50	43 545 179,05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21 545 699,62	32 908 881,51
210404	Ном, хэвлэл	3 630 190,00	21 891 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63 696 140,00	46 842 385,99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	39 566 787,80
210408	Бараа материал акталсны зардал	-	87 789 426,01
2105	Нормативт зардал	18 762 913 300,85	19 488 126 014,44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18 296 135 173,65	18 951 512 208,14
210502	Хоол, хүнс	410 627 295,20	475 643 151,30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56 150 832,00	60 970 655,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361 046 857,00	734 336 970,50
210601	Багаж, техник, хэрэгсэл	81 969 286,00	7 566 120,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	97 359 635,00	70 719 368,50
210604	Урсгал засвар	181 717 936,00	656 051 482,00
2107	Томилолт, зочны зардал	113 475 820,00	294 786 112,00
210701	Гадаад албан томилолт	85 446 320,00	194 241 720,00
210702	Дотоод албан томилолт	28 029 500,00	100 544 392,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75 432 851,00	160 729 353,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38 420 000,00	117 790 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 635 300,00	6 892 690,00
210803	Даатгалын үйлчилгээ	445 500,00	4 040 250,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495 000,00	487 560,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	103 900,00	160 000,00
210807	Газрын төлбөр	7 372 776,00	4 948 200,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4 098 600,00	4 098 600,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22 861 775,00	22 312 053,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4 946 996 998,14	5 537 471 277,68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102 558 058,00	781 258 120,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 293 467,52	38 263 680,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4 839 145 472,62	4 717 949 477,68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	512 499 208,01	309 768 058,79
2132	Бусад урсгал шилжүүлэг	511 840 862,00	292 205 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	511 840 862,00	292 205 900,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	658 346,01	17 562 158,79
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	658 346,01	17 562 158,79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2 323 184 770,80	-2 538 488 799,53
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	9 782 953,29	13 215 980,54
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	9 782 953,29	13 215 980,54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	8 948 067,36
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	8 948 067,36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	9 782 953,29	4 267 913,18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-2 313 401 817,51	-2 534 220 886,35

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>31 736 386 576,90</u>	<u>32 258 818 843,63</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4 254 406 922,70	4 600 278 343,63
120	Нийтлэг татварын бус орлого	4 254 406 922,70	4 600 278 343,63
120002	Хүүгийн орлого	5 707 490,15	12 300 151,23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4 248 699 432,55	4 587 978 192,40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4 115 135 432,55	4 407 258 192,40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133 564 000,00	180 720 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27 481 979 654,20	27 658 540 500,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5 145 554 600,00	5 222 196 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5 145 554 600,00	5 222 196 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 615 558 894,20	618 576 100,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1 228 693 085,00	8 016 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	377 652 200,00	239 272 100,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9 213 609,20	371 288 000,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20 720 866 160,00	21 817 768 400,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20 720 866 160,00	21 817 768 400,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>30 504 817 656,75</u>	<u>33 249 040 494,40</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30 504 817 656,75	33 249 040 494,40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29 777 728 448,74	32 713 240 749,61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8 295 449 152,73	8 503 568 545,71
210101	Үндсэн цалин	5 209 238 252,73	4 746 800 532,71
210102	Нэмэгдэл	1 657 005 200,00	2 634 663 800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	657 152 700,00	657 152 700,00
210104	Урамшуулал	469 553 000,00	464 951 513,00
210105	Гэрээт ажлын хөлс	302 500 000,00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	912 578 046,00	1 018 418 900,00
210201	Тэтгэврийн даатгал	912 578 046,00	682 746 500,00
210202	Тэтгэмжийн даатгал		83 918 100,00
210203	ҮОМШӨ-ний даатгал		67 134 500,00
210204	Ажилгүйдлийн даатгал		16 783 600,00
210205	Эрүүл мэндийн даатгал		167 836 200,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	737 850 400,00	731 713 820,84
210301	Гэрэл, цахилгаан	328 965 933,00	327 156 004,00
210302	Түлш, халаалт	219 452 680,39	195 239 735,00
210303	Цэвэр, бохир ус	189 431 786,61	209 318 081,84
2104	Хангамж, бараа материалын зардал	152 895 169,47	214 281 300,00
210401	Бичиг хэрэг	16 603 084,85	24 842 100,00
210402	Тээвэр, шатахуун	34 309 300,00	45 215 476,00

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18 916 199,62	32 908 881,51
210404	Ном, хэвлэл	3 604 090,00	21 891 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	49 274 900,00	44 464 039,69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30 187 595,00	44 959 802,80
2105	Нормативт зардал	4 982 161 337,02	5 164 545 923,18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4 457 064 228,02	4 516 182 435,28
210502	Хоол, хүнс	409 282 502,00	476 291 159,90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	115 814 607,00	172 072 328,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	409 263 146,00	983 543 257,80
210601	Багаж, техник, хэрэгсэл	163 972 304,00	259 770 876,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	68 785 200,00	67 441 899,80
210604	Урсгал засвар	176 505 642,00	656 330 482,00
2107	Томилолт, зочны зардал	113 475 820,00	294 786 112,00
210701	Гадаад албан томилолт	85 446 320,00	194 241 720,00
210702	Дотоод албан томилолт	28 029 500,00	100 544 392,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78 754 876,00	700 755 779,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38 420 000,00	658 051 479,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 635 300,00	6 892 690,00
210803	Даатгалын үйлчилгээ	445 500,00	4 040 250,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495 000,00	487 560,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	103 900,00	160 000,00
210807	Газрын төлбөр	7 372 776,00	4 948 200,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4 098 600,00	4 098 600,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26 183 800,00	22 077 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14 095 300 501,52	15 101 627 111,08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14 090 007 034,00	15 063 363 431,08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 293 467,52	38 263 680,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	727 089 208,01	535 799 744,79
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	533 530 862,00	292 205 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	271 081 862,00	292 205 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	262 449 000,00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	193 558 346,01	243 593 844,79
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	193 558 346,01	243 593 844,79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1 231 568 920,15</u>	<u>-990 221 650,77</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	156 382 750,00	81 861 488,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	156 382 750,00	81 861 488,00
2200	Дотоод эх үүсвэрээр	156 382 750,00	81 861 488,00
222001	Тоног төхөөрөмж	67 156 000,00	-
223001	Бусад хөрөнгө	89 226 750,00	81 861 488,00

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-156 382 750,00</u>	<u>-81 861 488,00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
14	Бусад эх үүсвэр	9 782 953,29	13 215 980,54
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	9 782 953,29	13 215 980,54
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	8 948 067,36
250001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	-	8 948 067,36
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>9 782 953,29</u>	<u>4 267 913,18</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1 084 969 123,44	-1 067 815 225,59
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1 084 969 123,44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1 084 969 123,44	17 153 897,85

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15 283 949 417,50	10 643 300 698,16	9 624 075 001,39	35 551 325 117,05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15 283 949 417,50	10 643 300 698,16	9 624 075 001,39	35 551 325 117,05
C07	Тайлант үеийн үр дүн			-2 313 401 817,51	- 2 313 401 817,51
C08	2017оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15 283 949 417,50	10 643 300 698,16	7 310 673 183,88	33 237 923 299,54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15 283 949 417,50	10 643 300 698,16	7 310 673 183,88	33 237 923 299,54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	1 820 695 020,00	10 374 215 938,87		12 194 910 958,87
D08	Тайлант үеийн үр дүн			-2 534 220 886,35	- 2 534 220 886,35
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17 104 644 437,50	21 017 516 637,03	4 776 452 297,53	42 898 613 372,06

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1 084 969 123,44		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33 983 957 404,00	33 339 850 049,76	644 107 354,24	98,1%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	33 691 751 504,00	32 795 102 237,61	896 649 266,39	97,3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24 169 763 994,00	23 273 114 791,90	896 649 202,10	96,3%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8 503 568 610,00	8 503 568 545,71	64,29	99,9%
210101	Үндсэн цалин	4 733 127 410,00	4 746 800 532,71	-13 673 122,71	100,3%
210102	Нэмэгдэл цалин	2 634 663 800,00	2 634 663 800,00	-	100,0%
210103	Унаа хоолны нэмэгдэл	657 152 700,00	657 152 700,00	-	100,0%
210104	Урамшуулал	478 624 700,00	464 951 513,00	13 673 187,00	97,1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1 018 418 900,00	1 018 418 900,00	-	100,0%
210201	Тэтгэврийн даатгал	682 746 500,00	682 746 500,00	-	100,0%
210202	Тэтгэмжийн даатгал	83 918 100,00	83 918 100,00	-	100,0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	67 134 500,00	67 134 500,00	-	100,0%
210204	Ажилгүйдлийн даатгал	16 783 600,00	16 783 600,00	-	100,0%
210205	Эрүүл мэндийн даатгал	167 836 200,00	167 836 200,00	-	100,0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	731 939 600,00	731 713 820,84	225 779,16	99,9%
210301	Гэрэл, цахилгаан	400 201 200,00	327 156 004,00	73 045 196,00	81,7%
210302	Түлш, халаалт	195 015 900,00	195 239 735,00	-223 835,00	100,1%
210303	Цэвэр, бохир ус	136 722 500,00	209 318 081,84	-72 595 581,84	153,1%
2104	Хангамж, бараа материалын зардал	214 281 300,00	214 281 300,00	-	100,0%
210401	Бичиг хэрэг	19 108 900,00	24 842 100,00	-5 733 200,00	130,0%
210402	Тээвэр, шатахуун	46 009 300,00	45 215 476,00	793 824,00	98,3%
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	37 809 600,00	32 908 881,51	4 900 718,49	87,0%
210404	Ном, хэвлэл	21 891 000,00	21 891 000,00	-	100,0%
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44 274 900,00	44 464 039,69	-189 139,69	100,4%
210406	БҮТЭЗҮЙЛС	45 187 600,00	44 959 802,80	227 797,20	99,5%
2105	Нормативт зардал	5 164 545 924,00	5 164 545 923,18	0,82	99,9%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4 464 633 524,00	4 516 182 435,28	-51 548 911,28	101,2%
210502	Хоол хүнс	527 833 500,00	476 291 159,90	51 542 340,10	90,2%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	172 078 900,00	172 072 328,00	6 572,00	99,9%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 061 504 846,00	1 061 504 845,80	0,20	99,9%
210601	Багаж, техник хэрэгсэл	276 812 776,00	276 686 076,00	126 700,00	99,9%
210602	Тавилга	61 046 388,00	61 046 388,00	0,00	100,0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	68 785 200,00	67 441 899,80	1 343 300,20	98,0%
210604	Урсгал засвар	654 860 482,00	656 330 482,00	-1 470 000,00	100,2%
2107	Томилолт, зочны зардал	294 786 112,00	294 786 112,00	-	100,0%
210701	Гадаад албан томилолт	208 941 720,00	194 241 720,00	14 700 000,00	93,0%
210702	Дотоод албан томилолт	85 844 392,00	100 544 392,00	-14 700 000,00	117,1%

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	704 710 429,00	704 655 679,00	54 750,00	99,9%
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	661 951 379,00	661 951 379,00	-	100,0%
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6 900 000,00	6 892 690,00	7 310,00	99,9%
210803	Даатгалын үйлчилгээ	4 040 250,00	4 040 250,00	-	100,0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	535 000,00	487 560,00	47 440,00	91,1%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160 000,00	160 000,00	-	100,0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15 997 995 783,00	15 101 627 111,08	896 368 671,92	94,4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15 959 732 103,00	15 063 363 431,08	896 368 671,92	94,4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38 263 680,00	38 263 680,00	-	100,0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292 205 900,00	535 799 744,79	-243 593 844,79	183,4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	292 205 900,00	292 205 900,00	-	100,0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	292 205 900,00	292 205 900,00	-	100,0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		243 593 844,79	243 593 844,79	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		243 593 844,79	243 593 844,79	
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		8 948 067,36	8 948 067,36	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33 080 605 800,00	32 272 034 824,17	808 570 975,83	97,6%
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0,00	12 300 151,23	12 300 151,23	
120002	Хүүгийн орлого	0,00	12 300 151,23	12 300 151,23	
1200041	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	5 241 345 300,00	4 407 258 192,40	834 087 107,60	84,1%
12000411	Үндсэн үйл ажиллагааны орлого	5 241 345 300,00	4 407 258 192,40	834 087 107,60	84,1%
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	180 720 000,00	180 720 000,00	-	100,0%
12000421	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	180 720 000,00	180 720 000,00	-	100,0%
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5 840 772 100,00	5 840 772 100,00	-	100,0%
131001	Улсын төсвөөс санхүүжих	5 222 196 000,00	5 222 196 000,00	-	100,0%
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого	618 576 100,00	618 576 100,00	-	100,0%
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21 817 768 400,00	21 817 768 400,00	-	100,0%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21 817 768 400,00	21 817 768 400,00	-	100,0%
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		13 215 980,54	13 215 980,54	
31	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		1 084 969 123,44	1 084 969 123,44	
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		17 153 897,85	17 153 897,85	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	728	728	-	100,0%
620001	Удирдах ажилтан	6	6	-	100,0%
620002	Гүйцэтгэх ажилтан	630	630	-	100,0%
620003	Үйлчлэх ажилтан	90	90	-	100,0%
650010	Гэрээт ажилтан	2	2	-	100,0%

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.02.25			САГ-2019//394/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй	834,087.1	Албан шаардлага хүргүүлэх	Эмнэлгийн дарга	Ц.Төмөр-Очир
				Санхүү эдийн засгийн албаны дарга	З.Отгон
2	Нэгжүүдийн усны хэрэглээнд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, зардлыг бууруулах зөвлөмжийг биелүүлээгүй, усны зардал төсвөөс хэтэрсэн	72,595.1	Албан шаардлага хүргүүлэх	Эмнэлгийн дарга	Ц.Төмөр-Очир
				Санхүү эдийн засгийн албаны дарга	З.Отгон
3	Анагаах ухааны хүрээлэнгийн зээмшиж буй өрөөнүүдийн ашиглалтын бодит зардал гэрээнд тусгасан зардлаас хэтэрсэн	1,108,3	Зөвлөмж өгөх	Эмнэлгийн дарга	Ц.Төмөр-Очир
				Санхүү эдийн засгийн албаны дарга	З.Отгон
Дүн		907,790.5			